# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2024/72/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2023 он


Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Даваанямм
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Б.Ариунтуяа
Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/99

танай ______-ны № ______-т

БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА М.БАТТУЛГА
ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянзүрх сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянзүрх сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд сумын ЗДТГ-ын барилга байгууламж 55,000.0 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 208,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 15,863.3 мянган төгрөг, мөн бусад хөрөнгө 30,000.0 мянган төгрөгөөр, нийт 308,863.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой нийт 12,141.6 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд таслан зогсоох албан шаардлагыг хүргүүлсэн.

### Бусад асуудлын хэсэг

Засаг даргын Тамгын газрын дарга нь сумын Засаг даргатай 2023 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө 7 зорилт, 49 арга хэмжээтэйгээр байгуулж, хэрэгжилтийг 94.4 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

6724040453

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,243,767.28** | **53,119,275.28** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 27,243,767.28 | 53,119,275.28 |
| **354** | **Хангамжийн материал** | 27,243,767.28 | 53,119,275.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,829,842.00 | 1,398,290.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,647,425.28 | 39,085,385.28 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 11,766,500.00 | 12,635,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,675,902,288.01** | **3,684,858,806.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,675,902,288.01 | 3,684,858,806.94 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,649,201,537.99 | 3,658,377,390.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,798,632,065.23 | 3,853,632,065.23 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -506,400,592.13 | -728,886,549.78 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 435,739,000.00 | 638,239,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -210,910,034.62 | -257,581,666.45 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 146,020,025.50 | 152,249,805.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -43,192,100.02 | -50,321,431.94 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,338,510.00 | 23,568,500.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10,085,336.00 | -11,602,332.68 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 14,800,000.00 | 44,800,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,739,999.97 | -5,719,999.95 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 26,700,750.02 | 26,481,416.71 |
| 39301 | Програм хангамж | 2,605,000.00 | 2,605,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,794,249.98 | -2,013,583.29 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,890,000.00 | 25,890,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,703,146,055.29** | **3,737,978,082.22** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,703,146,055.29** | **3,737,978,082.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,703,146,055.29 | 3,737,978,082.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 327,386,920.40 | 327,386,920.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 327,386,920.40 | 327,386,920.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,853,181,145.32 | 2,888,013,172.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,853,181,145.32 | 2,853,181,145.32 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 34,832,026.93 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 522,577,989.57 | 522,577,989.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,703,146,055.29** | **3,737,978,082.22** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **734,118,789.50** | **1,035,705,190.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **295,821,389.50** | **299,888,342.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 295,821,389.50 | 299,888,342.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 295,821,389.50 | 299,888,342.80 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 540,000.00 | 5,245,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 295,281,389.50 | 294,643,342.80 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **438,297,400.00** | **735,816,848.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,466,000.00 | 3,409,648.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 800,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,466,000.00 | 2,609,648.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 433,831,400.00 | 732,407,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 433,831,400.00 | 732,407,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **676,748,393.67** | **997,629,866.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **676,748,393.67** | **997,629,866.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 649,231,893.67 | 943,577,066.20 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 272,067,400.00 | 430,672,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 218,886,484.69 | 312,755,808.23 |
| 210102 | Нэмэгдэл | 39,031,017.31 | 102,306,621.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 7,695,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,149,898.00 | 7,915,169.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,839,400.00 | 54,256,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,677,200.00 | 36,498,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,805,600.00 | 3,838,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,228,400.00 | 4,152,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 557,100.00 | 887,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,571,100.00 | 8,878,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,653,568.00 | 34,963,327.54 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,439,800.00 | 7,912,227.54 |
| 210302 | Түлш, халаалт | 17,213,768.00 | 25,766,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 1,284,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,786,600.00 | 48,571,049.46 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,866,000.00 | 7,573,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,950,600.00 | 35,007,957.46 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,670,000.00 | 2,999,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 575,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 2,415,192.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,809,600.00 | 7,105,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 117,900.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,691,700.00 | 7,105,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,370,000.00 | 7,300,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,370,000.00 | 7,300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,945,740.00 | 37,236,963.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,895,740.00 | 34,933,263.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 160,000.00 | 108,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,000.00 | 149,274.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 91,113.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000.00 | 600,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 144,813.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 256,759,585.67 | 323,471,626.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,979,360.00 | 24,438,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,837,500.00 | 2,370,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 244,942,725.67 | 296,663,526.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 27,516,500.00 | 54,052,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,516,500.00 | 54,052,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,650,600.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 21,168,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,865,900.00 | 32,884,800.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **57,370,395.83** | **38,075,324.60** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 3,243,297.67 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 3,243,297.67 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -3,243,297.67 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **57,370,395.83** | **34,832,026.93** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **438,837,400.00** | **741,061,848.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **540,000.00** | **5,245,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 540,000.00 | 5,245,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 540,000.00 | 5,245,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 540,000.00 | 5,245,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **438,297,400.00** | **735,816,848.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,466,000.00 | 3,409,648.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 800,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,466,000.00 | 2,609,648.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 433,831,400.00 | 732,407,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 433,831,400.00 | 732,407,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **431,468,400.00** | **726,841,848.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **431,468,400.00** | **726,841,848.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **403,951,900.00** | **672,789,048.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 272,067,400.00 | 430,672,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 218,886,484.69 | 312,755,808.23 |
| 210102 | Нэмэгдэл | 39,031,017.31 | 102,306,621.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 7,695,000.00 |
| 210104 | Урамшуулал | 14,149,898.00 | 7,915,169.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,839,400.00 | 54,256,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,677,200.00 | 36,498,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,805,600.00 | 3,838,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,228,400.00 | 4,152,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 557,100.00 | 887,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,571,100.00 | 8,878,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,316,300.00 | 36,250,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,439,800.00 | 7,912,227.54 |
| 210302 | Түлш, халаалт | 16,876,500.00 | 26,592,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 1,745,772.46 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,786,600.00 | 42,880,348.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,866,000.00 | 6,964,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,950,600.00 | 32,341,548.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,670,000.00 | 3,000,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 574,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 1,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,809,600.00 | 16,600,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 117,900.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 9,435,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,691,700.00 | 7,165,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,370,000.00 | 7,300,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,370,000.00 | 7,300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,945,900.00 | 53,862,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,895,900.00 | 51,559,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 160,000.00 | 108,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,000.00 | 149,274.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 91,113.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000.00 | 600,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 144,813.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,816,700.00 | 29,966,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,979,200.00 | 20,966,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,837,500.00 | 9,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **27,516,500.00** | **54,052,800.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 27,516,500.00 | 54,052,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,650,600.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 21,168,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,865,900.00 | 32,884,800.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,369,000.00** | **14,220,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,369,000.00** | **14,220,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,369,000.00** | **14,220,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,369,000.00 | 14,220,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,369,000.00 | 14,220,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-7,369,000.00** | **-14,220,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 327,386,920.40 | 522,777,973.57 | 1,255,442,030.95 | 2,105,606,924.92 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 199,984.00 | 199,984.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,777,973.57** | **1,255,642,014.95** | 2,105,806,908.92 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,539,618,734.54 | 1,539,618,734.54 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,853,181,145.32** | 3,703,146,055.29 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,853,181,145.32** | 3,703,146,055.29 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,853,181,145.32** | 3,703,146,055.29 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 34,832,026.93 | 34,832,026.93 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **327,386,920.40** | **522,577,989.57** | **2,888,013,172.25** | 3,737,978,082.22 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | |
|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 732,407,200.00 | 732,407,200.00 | 0.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 732,407,200.00 | 732,407,200.00 | 0.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 678,554,400.00 | 678,554,400.00 | 0.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 430,672,600.00 | 430,672,600.00 | 0.00 |
| 210101 | Үндсэн цалин | 430,672,600.00 | 312,755,808.23 | -117916791.77 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 102,306,621.94 | 102306621.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 7,695,000.00 | 7695000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 7,915,169.83 | 7915169.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 54,256,000.00 | 54,256,000.00 | 0.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,498,300.00 | 36,498,300.00 | 0.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,838,300.00 | 3,838,300.00 | 0.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,152,600.00 | 4,152,600.00 | 0.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 887,900.00 | 887,900.00 | 0.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,878,900.00 | 8,878,900.00 | 0.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 36,250,000.00 | 36,250,000.00 | 0.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,500,000.00 | 7,912,227.54 | -1587772.46 |
| 210302 | Түлш, халаалт | 26,600,000.00 | 26,592,000.00 | -8000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 150,000.00 | 1,745,772.46 | 1,595,772.46 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,509,700.00 | 40,509,700.00 | 0.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,545,000.00 | 6,545,000.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,389,900.00 | 30,389,900.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 574,800.00 | 574,800.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 30,820,700.00 | 30,820,700.00 | 0.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,532,700.00 | 12,532,700.00 | 0.00 |
| 210602 | Тавилга | 11,122,500.00 | 11,122,500.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,165,500.00 | 7,165,500.00 | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,650,000.00 | 6,650,000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,650,000.00 | 6,650,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 48,862,900.00 | 48,862,900.00 | 0.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 46,559,200.00 | 46,559,200.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,209,600.00 | 1,209,600.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,900.00 | 108,900.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 149,274.00 | 149,274.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 91,113.00 | 91,113.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 600,000.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 144,813.00 | 144,813.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29532500.00 | 29532500.00 | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,532,500.00 | 20,532,500.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,000,000.00 | 9,000,000.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 53852800.00 | 53852800.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 53,852,800.00 | 53,852,800.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,168,000.00 | 21,168,000.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 32,684,800.00 | 32,684,800.00 | 0.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 732,407,200.00 | 732,407,200.00 | 0.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 732,407,200.00 | 732,407,200.00 | 0.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 732,407,200.00 | 732,407,200.00 | 0.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 26.00 | 0.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 | 0.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 17.00 | 0.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 | 0.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **26.00** | **26.00** | 0.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 09.00 | 09.00 | 0.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06.00 | 06.00 | 0.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 07.00 | 07.00 | 0.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **8,654,648.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **8,654,648.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 8,454,648.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 2,370,648.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 419,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,951,648.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 650,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 650,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 5,000,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 5,000,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 434000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 434,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 200000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 200,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 8654648.00 |
| | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | 5245000.00 |
| | **Үндсэн үйл ажиллагааны орлоггос санхүүжих** | | 5245000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 3,409,648.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 00.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 800,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,609,648.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 00.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | 00.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,141.6 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрснээс 2,960.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 9,181.6 мянган төгрөгийн зөрчилд таслан зогсоох албан шаардлагыг Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

**5.1 Төлбөрийн акт:** Байгууллагын төсвөөс алба хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах замын зардал гэж 2,960.0 төгрөгийг нярвын дансаар гарган авч, хоол, буудал, бусад бараа материал авч үр ашиггүй зарцуулсан байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*Төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**5.2 Албан шаардлага**

Баянзүрх сумын ЗДТГ нь Чанартай сүрэг ХХК-аас бараа материал болон бусад тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө бэлтгэхдээ шууд гэрээ байгуулах аргыг ашиглаж байгаа боловч урилгыг цахим системд нийтлээгүй, төсвийн хөрөнгөөр шаардлагагүйгээр их хэмжээний аяга, таваг, халбага, сэрээ, хундага гэх мэт нийт 9,181.6 мянган төгрөгийн материал бэлтгэж, нөөцөлсөн, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т *“Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д заасны дагуу аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ*” болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 *“нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”,* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”* заалтууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 2,960.0 | 1 | 2,960.0 | | | | | | |
| Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй | 1 | 9,181.6 | | | 1 | 9,181.6 | | | | |
| **Дүн** | **2** | **12,141.6** | **1** | **2,960.0** | **1** | **9,181.6** | | | | |